

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн
2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2026/012/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 7036-3040 Ахлах аудитор: Утас: 7036-3036	Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Ц.Отгонбаяр Цахим хаяг: Otgonbayrts@audit.gov.mn
Сүхбаатар сум 2026 он	Аудитор: Утас: 7036-2442	Р.Отгонжаргал Цахим хаяг: Otgonjargalr@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.25 № 02А-2026/012/НА-СТА-ТБ
танай _____-ны № _____-т

**БАРУУНБҮРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.ОТГОНБААСАН ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Баруунбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд сумын төсөв болон ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар нийт 22 төсөл, арга хэмжээнд 1,198,367.0 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 935,560.2 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 262,806.8 мянган төгрөг хэмнэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 15 хөтөлбөрийн 39 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,773,736.4 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,455,369.4 мянган төгрөгийг урсгал зардалд, 1,198,367.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 120,000.0 мянган төгрөгийг ХХС-ийн зээлд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,112,357.6 мянган төгрөг буюу 82.4 хувьтай байгаа нь урсгал зардлыг 391,608.6 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 251,876.2 мянган төгрөгөөр, эргэж төлөгдөх зээлийг 17,839.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тайлант онд Баруунбүрэн сумын Засаг дарга нь 4 зорилт, 76 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 90.4 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,353,201.89	1,168,931.28
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	1,142,951.21	862,437.32
3	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	119,619.18	182,939.38
4	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	90,631.49	123,554.58
5	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		7,566,976.38	9,570,747.58
6	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	7,566,976.38	9,570,747.58
7	Биет хөрөнгө		7,248,808.52	9,080,865.68
8	Биет бус хөрөнгө	13	318,167.87	489,881.9
9	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		8,920,178.27	10,739,678.86
10	НИЙТ ӨР ТӨЛБӨР		71.71	1,746.72
11	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		71.71	1,746.72
12	Өглөг		71.71	1,746.72
13	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		8,920,106.56	10,737,932.14
14	Засгийн газрын хувь оролцоо		8,920,106.56	10,737,932.14
15	Засгийн газрын оруулсан капитал		278,919.31	278,919.31
16	Хуримтлагдсан үр дүн		8,430,463.14	10,248,288.72
17	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		210,724.11	210,724.11
18	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		8,920,178.27	10,739,678.86

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		7,242,873.78	6,081,865.06
2	ТАТВАРЫН ОРЛОГО		1,149,377.08	1,051,983.88
3	Орлогын албан татвар		526,190.8	555,741.48
4	Хувь хүний орлогын албан татвар		551,803.61	575,906.93
5	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-25,612.81	-20,165.45
6	Хөрөнгийн албан татвар		226,049.94	230,788.57
7	Бусад татвар, төлбөр, хураамж		397,136.34	265,453.83
8	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	4,264,028.32	5,029,881.17
9	Тусламжийн орлого		0.0	931,330.5
10	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,829,468.38	0.0
11	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	2,393,023.24	3,300,545.94
12	УРСГАЛ ЗАРДАЛ		2,393,023.24	3,300,545.94
13	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,306,814.13	3,271,924.50
14	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		891,717.38	1,018,422.59
15	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		109,265.31	120,558.87
16	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		414,517.16	460,499.02

17	Хангамж, бараа материалын зардал		86,153.71	79,457.85
18	Норматив зардал		0.0	2,995
19	Эд хогшил, урсгал засварын зардал		133,038	82,161.98
20	Томилолт, зочны зардал		13,705.85	11,870
21	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		25,058.68	90,557.66
22	Бараа үйлчилгээний бусад зардал		633,358.03	1,405,401.51
23	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		86,209.12	28,621.44
24	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		4,849,850.54	2,781,319.12
25	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		473,384.91	963,493.54
26	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		-473,384.91	-963,493.54
27	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		4,376,465.63	1,817,825.58

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,543,640.93	-	4,543,640.93
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,543,640.93	-	4,543,640.93
3	Тайлант үеийн үр дүн	4,376,465.63	-	4,376,465.63
4	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,920,106.56	-	8,920,106.56
5	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	8,920,106.56	-	8,920,106.56
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,920,106.56	-	8,920,106.56
7	Тайлант үеийн үр дүн	1,817,825.58	-	1,817,825.58
8	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	10,737,932.14	-	10,737,932.14

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	3,225,570.17	2,852,563.59
2	ТАТВАРЫН ОРЛОГО	1,149,377.08	1,051,983.88
3	Орлогын албан татвар	526,190.8	555,741.48
4	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-25,612.81	-20,165.45
5	Хөрөнгийн албан татвар	226,049.94	230,788.57
6	Бусад татвар, төлбөр, хураамж	397,136.34	265,453.83
7	Бусад нийтлэг төлбөр, хураамж	17,664.39	21,693.01
8	Газрын төлбөр	242,990.95	42,058.25
9	Байгалийн нөөц ашигласны төлбөр	136,481	201,702.57
10	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	246,724.7	1,800,579.71
11	Нийтлэг татварын бус орлого	246,724.7	199,571.94
12	Тусламжийн орлого	0.0	938,094.87
13	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	662,912.9
14	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,829,468.38	0.0
15	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,823,299.34	2,086,586.61
16	УРСГАЛ ЗАРДАЛ	1,823,299.34	2,086,586.61
17	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,737,090.22	2,057,965.17
18	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	891,717.38	1,018,332.59
19	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	109,265.31	120,558.87
20	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	414,517.16	460,496.23
21	Хангамж, бараа материалын зардал	60,616.83	56,413.94
22	Норматив зардал	504	6,179
23	Эд хогшил, урсгал засварын зардал	138,037.6	126,732.5
24	Томилолт, зочны зардал	13,705.85	11,960
25	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,419.78	154,563.8
26	Бараа үйлчилгээний бусад зардал	79,306.31	102,728.23
27	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	86,209.12	28,621.44
28	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,402,270.83	765,976.99
29	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	547,370.11	946,490.87
30	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	547,370.11	946,490.87
31	Дотоод эх үүсвэрээр	547,370.11	946,490.87
32	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-547,370.11	-946,490.87
33	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	100,000
34	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	-100,000
35	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	854,900.72	-280,513.88
36	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	288,050.48	1,142,951.21
37	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,142,951.21	862,437.32

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Дүн	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,773,736.40	3,112,357.70	661,378.70	82.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,457,475.50	2,065,866.90	391,608.60	84.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,426,132.80	2,038,010.40	388,122.40	84.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	1,174,205.00	1,018,332.50	155,872.50	86.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	148,020.70	120,558.80	27,461.90	81.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	582,331.30	460,496.20	121,835.10	79.1
2104	Хангамж, бараа материалын зардал	61,459.90	51,339.40	10,120.50	83.5
2105	Норматив зардал	5,179.00	5,179.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	133,974.30	126,732.50	7,241.80	94.6
2107	Томилолт, зочны зардал	17,025.70	11,960.00	5,065.70	70.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	192,529.90	141,683.80	50,846.10	73.6
2109	Бараа, үйлчилгээний бусад зардал	111,407.00	101,728.20	9,678.80	91.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,342.70	27,856.50	3,486.20	88.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,342.70	27,856.50	3,486.20	88.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,198,367.00	946,490.80	251,876.20	79.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	117,893.90	100,000.00	17,893.90	84.8
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,773,736.40	3,276,554.50	497,181.90	86.8
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,660,036.40	3,167,449.90	492,586.50	86.5
320001	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,997,123.50	2,220,959.10	776,164.40	74.1
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	662,912.90	946,490.80	(283,577.90)	142.8
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	113,700.00	109,104.60	4,595.40	96.0
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	113,700.00	109,104.60	4,595.40	96.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
610001	БАЙГУУЛЛАГЫН ТОО	3.00	3.00	-	100.0
86.1	АЖИЛЛАГСДЫН ТОО	36.00	31.00	5.00	86.1
620001	Удирдах ажилтан	9.00	9.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	17.00	14.00	3.00	82.4
620003	Үйлчлэх ажилтан	-	-	-	-
620004	Гэрээт ажилтан	10.00	9.00	1.00	90.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	36.00	31.00	5.00	86.1
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11.00	7.00	4.00	63.6
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8.00	7.00	1.00	87.5
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	6.00	6.00	-	100.0
650012	Гэрээт	11.00	11.00	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Тайлант он
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	20,719.37
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20,719.37
122	Тусламжийн орлого	20,719.37
1221	Хандив тусламж /дотоод/	20,719.37
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,719.37
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,579.37
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,140.00
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	20,719.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	20,719.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	19,954.48
2104	Хангамж, бараа материалын зардал	5,074.48
210401	Бичиг хэрэг	1,340.00
210402	Тээвэр, шатахуун	3,554.48
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	180.00
2105	Норматив зардал	1,000.00
210502	Хоол, хүнс	1,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,880.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,880.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	764.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	764.89
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	764.89

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **76,059.5** мянган төгрөгийн зөрчил илэрснээс 7,956.2 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 68,103.3 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 7,956.2 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон 23,930.2 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс 15,974.0 мянган төгрөгөөр бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

Сумын ЗДТГ:

1. Санхүүгийн тайланд 1,522.6 мянган төгрөгийн 3-аас дээш жилийн насжилттай авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй, авлагыг барагдуулах үр дүнтэй арга хэмжээ зохион байгуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх,

бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдээдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8 дахь “Өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдээдлийг тооцсон байх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Олон жилийн насжилттай авлагыг тооцоо нийлж баталгаажуулж, барагдуулах арга хэмжээ авах албан шаардлага хүргүүлэв.

2. Хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан ажилтны ажлыг мэргэшсэн бус ЗДТГ-ын дарга Л.Балжинням хавсран гүйцэтгүүлж, үндсэн цалингийн 15 хувиар тооцож, нийт 3,009.4 мянган төгрөгийн нэмэгдэл олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4 дэх *“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтнаар инженер, техникийн болон эрүүл ахуйн боловсролтой, мэргэшсэн хүнийг ажиллуулна”* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ХАБ-ын албан үүргийг мэргэшсэн сургалтад хамрагдсан албан хаагчаар хавсран гүйцэтгүүлэх албан шаардлага хүргүүлэв.

3. Өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 22 нэр төрлийн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-т *“илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.2 дахь *“Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 4.2.1.10 “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол,”* гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв

Сумын ИТХ:

1. Бараа үйлчилгээний бусад зардлаас шатахууны зардалд 516.6 мянган төгрөг, БҮТЭЗ-д 1,611.0 мянган төгрөг нийт 2,127.6 мянган төгрөгийг бүлэг хооронд гүйлгэн зориулалт бусаар зарцуулсан, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь *“Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”* гэсэн заалтууд болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан *“Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”*-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үнэн зөв тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

Сумын ИТХ:

- Ажлын албаны мэргэжилтэн Т.Энхтуулд ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүйгээс 233.3 мянган төгрөгийн цалинг давхардуулсан,

Сум дундын ойн анги:

- Техникч А.Гэрэлчулуунд ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүйгээс 1,063.3 мянган төгрөгийн цалинг давхардуулсан,

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 дэх “Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Биеэр бүрэн эдлээгүй ээлжийн амралтыг нөхөн эдлүүлэх албан шаардлага хүргүүлэв.

3.2 Зөвлөмж

Төсвийн төвлөрүүлэн захирагч:

1. Хоршоо хөгжүүлэх сангийн зээлтэй холбоотой:

1.1 Илрүүлэлт: ХХС-ийн чанаргүй зээлийн хэмжээ нийт зээлийн 38.8 хувь буюу 68,103.3 мянган төгрөг байгаа атал зээл төлүүлэх үр дүнтэй арга хэмжээ аваагүй, хууль хяналтын байгууллагад шилжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 7.1 дэх Сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагааны үр дүнг дараах зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээр үнэлнэ: 2 “Чанаргүй зээлийн хэмжээ-Нийт хөрөнгийн 10 хувиас бага байх”, 10.5 дахь “Зээлдэгчийн гэрээнд эрсдэл үүссэн тохиолдолд зээлийн хөрөнгийг эргүүлэн татах ажиллагааг сумын Засаг дарга болон хяналтын зөвлөл хариуцан зохион байгуулна. Энэхүү зохицуулалтыг зээлийн гэрээгээр нарийвчлан зохицуулна” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд “УСНББОУС-2: Мөнгөн хөрөнгө санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Чанаргүй зээлийн үлдэгдлийг бууруулах шат дараалсан арга хэмжээг авч ажиллах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТТЗ	1	68,103.3					1	68,103.3
ЗДТГ	3	4,532.0	-	-	3	4,532.0		
ИТХ	2	2,360.9	-	-	2	2,360.9		
Ойн анги	1	1,063.3			1	1,063.3		
Нийт дүн	7	76,059.5	-	-	6	7,956.2	1	68,103.3

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								